



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

**“Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалт, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх “Хэрэмт цамхаг” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, нийт 39,839,720.00 (гучин есөн сая найман зуун гучин есөн мянга долоон зуун хорь) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Н.Нандинболор нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төрийн өмчийн төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4.Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000658
9-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2025 оны 08 дүгээр сарын 17-ны өдрийн
208 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ "ХЭРЭМТ ЦАМХАГ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЭГ-ын 2024 оны 489 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Зил-130, ам-22 өргөгч крантай 45-56 УБХ	1993/2007	29,000,000.00	29,000,000.00	-	2,700,000.00	2,000,000.00
2	Ачигч трактор /жижиг/	2007	10,839,720.00	10,839,720.00	-	1,500,000.00	750,000.00
	Нийт үнэ		39,839,720.00 (гучин есөн сая найман зуун гучин есөн мянга долоон зуун хорь)	39,839,720.00 (гучин есөн сая найман зуун гучин есөн мянга долоон зуун хорь)	-	4,200,000.00 (дөрвөн сая хоёр зуу)	2,750,000.00 (хоёр сая долоон зуун тавь)